

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсанжамц	Дугаар	Л183
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Цогт
Төрсөн газар	Цогт сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	<b>Төгрөгийн хийд</b>	Сүм хийдийн дугаар	ГАЦГ 101
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Цогт сумын **Төгрөгийн** хийд

Асуулт:-Лувсанжамц гуай бидэнд тус сумын нутагт байсан **Төгрөгийн** хийдийн түүхийг ярьж өгнө үү.

Хариулт:-Хуучин Засагт хан аймгийн Толь гүний хошуу, ингээд хүрээ хийдийн байдлыг сонирхож үзэхэд улсад туслагч гүн итгэмжит **Билэгбалсангийн** үед 1728 онд **Цогчэн**, Хайлан хурлын дуганууд байгуулж байсан байгаа юм. Дараа нь бүрэн засагчин оны мөн үед гүн Дашцэрэнгийн үед **дүйнхор**, **гүнриг**, **цанид**, манал, **ламрин** хурлууд байгуулж, сургууль тогтоосон бөгөөд эдгээр хүрээ хийд нь Бурхан буудай уулын энгэр Төгрөг хэмээх газар суурьшин өнгөрсөн зууны 30-аад оны сүүлчээр 1937 оныг хүртэл хурал номын үйл ажиллагаа явагдаж байсан байгаа юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ингээд энэ хийдийн Цогчэн дуганы гол нэр нь **Чүлтэмдэчилэн** хийд.Энэ хийдэд 5 гэгээнтэн тодорч байсан.5 гэгээнтний 3-ын зураг хөрөг байдаг.Хоёр хувилгааны бунхан нь энд байдаг. Нэг гэгээнтэн нь Содын Дашцэрэн гэж 3 настай нь тодруулаад 5 настай ширээнд залаад 12 настай засаг төрийн нийгмийн үймээний үед 1937 онд баруун тийшээ гараад тэгээд Өвөр монголд Толь гүн гэдэг хүрээ хийд байгуулаад тэр нь Хятадын соёлын хувьсгалд үрэгдээд ингээд цаашилж явж **Гүмбэн** ороод **Гүмбэнд** суралцаж байгаад, тэнд ном хурлын ажил хийгээд **Гүмбэнгийн** улирлын хамбаар 4 удаа сууж байсан ийм түүхтэй хүн. Энэ нь хожим Хятад соёлынхоо өвийг сэргээж эхлэхэд Ажаа гэгээн **рэмбүүчитэйГүмбэнг** сэргээхэд 10 жил хүч хөдөлмөрөө зориулсан ийм учиртай.Энэ гэгээнтэнтэй нутаг хошуундаа 1993, 1995 онуудад хоёр удаа заларч ирж сүсэгтэн олонд адис **жанлав** өгсөн ийм түүхтэй юм.

Асуулт:-Энэ гэгээнтэн цэвэр монгол хүн үү?

Хариулт:-Энэ гэгээнтэн бол цэвэр халх. Энэ хүн бол 9 эрдэнийн пайзтайгаа, цорж малгайтайгаа, гэгээнтнийхээ бүстэйгээ, бусдыг эдэлж хэрэглэж байсан нь түүхэн зүйл нь Говь-Алтай аймгийн Цогт суманд**Гүмбэнгээс** хадгалагдаж байгаа.Энэ хүрээ хийд бол хэд хэдэн онцлогтой.Монголын тусгаар тогтнолыг хамгаалахад Далай ламын элч түүхийн 5 номон дээр Далайн давааны арын орон гэж байгаа.Тэнд анхны элч төлөөлөгч нь энэ Ээж буланд ирж сууж байсан ийм учиртай.

Нөгөө даяанч хийж байсан лам нь хамаргүй ламын агуй гэж эндээс **урагш** 68 км-т байна.Далайн түвшнээс дээш 3200 км өргөгдсөн тийм юмны оройд хоёр ихэр агуйтай, тэнд бас хэрэглэж барьж байсан юмыг нь Монгол улсын хөдөлмөрийн баатар, ямаачин Цэрэндондог гэж хүн одоогийн хэлдгээр музей болгосон.Ингээд улсууд орж гардаг ийм юм байгаа юм.

Ээж хайрханд даяанч хийж байсан ламын 3 агуй байдаг.Хамгийн сүүлд нь Дамбийжаагийн элч төлөөлөгч лам суугаад ингээд дуусгавар болсон. Энэ улсуудын хэрэглэж барьж байсан юм, тахиж байсан овоо, суурьшиж байсан 3 хаалгатай **ламрин**, өвлийн 8 метрийн агуй, улсууд, гийчидтэй уулздаг уулзалтын агуй эд нар нь одоо хүртэл **хадгалагдаж** байдаг юм.

Асуулт:-Төгрөгийн хүрээ 1937 оноос өмнө хэд орчим лам **хуврагатай**, тэргүүлж байсан лам нь хэн байсан бэ?

Хариулт:-Энэ тэргүүлж байсан лам нь гэхээр ерөөсөө хувилгаан лам нь **яачихдаг**, дандаа ловонгууд тэргүүлж байсан. Ганжуур ловон, **Бандхи лам**, Пэрэнлэй унзад гээд, сүүлийн улсууд нь.Түрүүчийн улсуудыг нь бид сайн мэдэхгүй шүү дээ.Ингээд үе дамжаад дамжаад хэрэглэж байсан.

Одоо Хархорины **подваль** доор хадгалагдаж байгаа **Алтангомбогүр бурханыг** энэ Баруун зуугаас залахад энд ирж энд Дүйнхэрийн **ван** тавьж байсан тийм түүхтэй.Дүйнхэрийн **ван** тавьж байсан хэрэглэлүүд нь энд байдаг.Тэр үеийн Богдын хөрөг зураг байдаг.Энд хийддээ хоёр сэнтий дандаа засдаг юм.Яагаад гэвэл дахиад шашин сэргэхэд Богд залрах түүхтэй гэж тэр хувилгаан хэлж байсан учраас нэг хийдэд илүү сэнтий бэлгэдэж **засч** байдаг. Энэ бол олон түүхийн юм бий. Энд юу гэхээр сая гаруй номын фонд сантай байсан дээр үед.Одоо болхад агуйд нуусан, олон түмэнд хадгалагдаж байсан 8000 гаруй нэг бүрчлэн судраар нь хөөх юм бол ийм ном байна.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

**Данжуур** бүхлээрээ байна.**Данжуурын** дүйв байна, Ганжуур байна, Жандагийн эздийн хэрэглэдэг бүх ном байна.Яг энэний хурал номын ажиллагаа явуулж байсан энэ халх гэгээний сууж байсан нэг ач холбогдол байдаг юм.Дандаа монгол хэл дээрээ санг тавьж байсан.Бурхан буудай уулын сан монгол дээр, Ээж хайрханы сан монгол дээр, энд 13 овоотой тахилгын. 13 овоо ухаандаа **Гэцэн** салын овоо гэхэд буян хурх, овоо нь Цэнхэрийн овоо гэхэд бороо оруулах, Шарын толгойтын овоо гэхэд өнтэй өвөлжих, энэ урд Жалцан шалба гэдэг юм энэний овоо нь ноён нурууных, энэ доор Цогт овоо гэж гэгээнтэн л гарч тахидаг, өөр хүн гарч **тахидаггүй** тийм том овоо байна, бүр давхар чулуун шаттай. Эндээс Отгонтэнгэрийн орой харагдаж байдаг, тэнгэр цэлмэг байхад.Хойшоо Мөнххайрханы орой харагдаж байдаг уулын орой дээр ийм байна.Энэ нь газар усанд тахиж байдаг.За тэгээд 13 овоотой, 13 овоо нь бүгд доороосоо авангуутаа дээр үеийнхээ ингэж яаж байсан.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан?

Хариулт:-Сүүлийн үедээ 300 гаруй ламтай. 1937 оны үед 300 ламтай байж байж тарсан гэж байгаа юм.Энд маш олон бэрхшээлийг ард түмэн үзэж байсан. Одоо манай сумын урагшаа хятадын хилд хаагдаж байсан юм. Миний садангууд хүртэл байна.Би одоо урагшаа явахдаа садангуудаа эргэдэг.102 айлын, одоо хятад хүргэнээ оруулаад 2500 гаруй ийм хүн байна.

Манай сумын гэгээнтэн **Нань** гэгээнтэн гэдэг юм.**Нань** гэгээнтний шавь нар **Гүмбэнд** 13 хутагт хувилгаад байгаагийн 5 хутагт хувилгаад нь манай сумын гэгээнтний шавь нар байна.Наашлаад Өмнөговь аймгийн**Гашуун сухайтаар** гарахаар цаад Далайхүү хотод өндөр гэгээн Жасрай гэж жинхэнэ баруун гарын шавь нь.Өөрийн баруун гарын шавь ийм хүн байна.Тэгээд ерөөсөө манай нутаг хошуунд хамгийн гол нь зан заншлыг яасан, Чойрын ном бий шүү дээ, философи.Тэрнийг их дагнасан.Уламжлалыг, зан заншлыг л нарийн шашны утга учиртай холбож өгсөн.Гол нь мухар сүжиг, ингээд уншаад тэр бузартсан гэдэг юмуу, энэ бузартсан гэдэг тийм юмыг голлодоггүй.Ерөөсөө л энэ нутаг хошуунд, одоо манай нутаг хошуунд уламжлаад ирсэн хөгшчүүлээс дээр үед яаж байсан гэхээр хурдан морио уралдуулахад сумынхаа санг, бөхөө барилдуулахад санг, монгол хэл дээр уншиж байгаа.

Энэ юунд хэд хэдэн онцлог бий.Ноднин Чингисийн 800 жилийн ойгоор Чингисийн нэр ус орсон юмнууд их байдаг юм.Энэ урд хил дээр Чингисийн уул байна.**Эдрэнгийн** нуруу гэж байна, Гүег хааны үеийн байлдаантай холбогдсон юм байна.Энэ хийддээ манайх 13 маань ая дангаар нь хөгжөөж уншдаг юм.Гэгээнтэн заагаад өгчихсөн. Тэр дотор 8 шаргал морь юугаа унаад, ухаан сайт нохой юугаа дагуулаад, 9 их хар шувуу юугаа нисгээд, 9 сүлдэн тэнгэртээ мөргөв, эзэн хаан Чингистээ мөргөв гэж. Тэгээд ум **маани** бад **мэ** хүм гээд уншаад байдаг.Бүр ингээд дагначихсан.Тэгээд энд гэгээнтний гэрээслэл гэж асар их юм байна.Тэр яадаг вэ гэхээр айл болоход **яахав**, ивээл харш жил **яахав**, хүүхэд төрөхөд **яахав**, хүүхдийн сэвлэг үргээхэд **яахав**.Ингээд бүр нарийн.Цайныхаа дээжийг өргөхөд юу гэж **өргөхөв**, ингээд бүр багаас нь.Манай тэр гэгээнтэн бол энд нэг ирээд сэхээтнүүдтэй уулзаад нэг химийн багш маргаж байлаа л даа.**Томъёогоор**. Тэгээд паг болж байсан.Тийм түүхтэй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Төгрөгийн хүрээний гол шүтээн нь ямар бурхан байсан бэ?

Хариулт:-Дивангар шүтээн. Манай дивангар шүтээнээр шашны дээд сургуулийн захирал Сонинбаяр бүр ном гаргаад диссертаци бичсэн.Сонинбаяр гуай андахгүй.Дагавар тэдэн бурхан, Цогтын шүтээн тийм.Тэгээд дараачийн шүтээнүүд нь улаан сахиус байна.Тэгээд 10 **хангал**, Засагт хан аймаг бол хаа ч байдаг шүү дээ.10 **хангал**, Очирваань гээд.Манайх ганцхан шашны дагнадаггүй энд нэг онцлог байдаг юм.Төрөө хүндэлдэг.Энд та нар ороод үзэхэд үзнэ.Энд шашны энэ жилийн Пүрэвбатын Улаанбаатарын Ганданд хийсгэсэн тугны **эскиз** тэр чигээрээ энд байна.Ерөөсөө Монголд шашны туг гуравхан байдаг юм шүү дээ, нэг туг нь энд.Энүүгээр хийсэн туг энэ жил хийсгээд байлаа шүү дээ.Занабазар богдын.Тэгээд энд хийж байсан нарийн нарийн хийц юм.

Энд бурханч лам Базардарь гэж монголын соёлын түүхэнд 2-р зэргийн зураач гэж орсон.Бурханч лам Пүрэвбат бол андахгүй.Тэр хүн юугаар давамгай байсан гэхээр нэг ширхэг үснээс 5 үсээр зурж байсан.Бүтээлүүдийн **дээж** нь энд байна. Улсын уралдаанд явж байсан.Ийм улсууддаа.

Асуулт:-Энэ Төгрөгийн хүрээ бол аль урсгал байсан юм бол, шар уу, улаан уу?

Хариулт:-Шарын урсгал. Шарын ч урсгалтай, улааны ч урсгалтай, хөхийн ч урсгалтай.

Асуулт:-**Жод лүйжин** тавьдаг байсан уу?

Хариулт:-Тавилгүй **яхав**, одоо хэрэглэлүүд нь хүртэл байж байна шүү дээ.

Асуулт:-Та тэр **Жод лүйжин** тавьдаг байсан лам нарын нэр алдрыг мэдэх үү?

Хариулт:-Шажин Чойжин гэж бүр тийм тодорхой хүн байна. Манайхан чинь **жодлүйжингээ** тавихаар хийд дугандаа хамаардаггүй.Бөө авчрахаах нөгөө бөөг хүчгүй болгодог.Нөгөө талаар энд маанийн бумба гурав дахин дэлбэрч байсан.Тэрний баталгаа ийм юм энд байж байдаг.Энд бол хурал номын ажил явуулаад ингэтэл дутуу юм байдаггүй, харин суух лам байдаггүй.

Асуулт:-Төгрөгийн хүрээний ном судраа **барладаг** бар байсан болов уу?

Хариулт:-Байлгүй **яхав**. Энэ янз бүрийн барууд асар их байсан гэж байгаа юм. Ерөөсөө та нар дээр очоод зарим **барлачихсан** байж байгаа юмнуудыг үзнэ л дээ.

Асуулт:-Монгол бар байсан уу? Монголоор ном судраа уншдаг байсан гэсэн.

Хариулт:-Монгол бар байлгүй **яхав**. Монгол бартай, түвд бартай.

Асуулт:-Уйгаржин монгол бичгээр бичсэн байгаа юу?

Хариулт:-Уйгаржин монгол бичгээр, тэгээд энэ чинь бүр тусдаа барын газартай, одоо юу гэдэг билээ, би мартчихаад байна. Хөгшчүүл ярьдаг.Тусдаа. Зөвхөн ном барлаад уйгар, монголоор барлаад ингээд дацанд тараагаад, **жандагийн** эзэнд тараагаад ингээд байж байдаг.

Асуулт :-Бас тийм хэвлэх үйлдвэртэй?

Хариулт:-Хэвлэх үйлдвэртэй. Иймэрхүү газар л даа.

Асуулт:-Сая та сумын төвийн ойролцоо байгаа овоонуудыг тахидаг байсан гэж ярилаа шүү дээ. Монгол сан тавиад.Тэрнийг ямархуу зан үйлээр тахидаг байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Энэ ингэнэ. Ээж уул бол тэр тахилгын наад талд буян хишгийн агуй гэж бүр энэ гэрээс том.Одоо ч гэсэн тэр овоо нь байна л даа.Тэр нь ингээд 4 мод шатлаад тавиад байна.**Жинхар** бэлдэнэ гэж нөгөө мал муулаад, арьсыг нь 4 шийртэй нь шар усанд дүрж зумлаад, тэгээд дээр нь цагаан идээгээ хийгээд, тэгээд дээр нь хөндлөн модтой нөгөө аравнай шүншиг яадаг. Тэр лүү нь аравнай **шүншигийг** нь дүүжлээд тэгээд ингээд ном.Эд нар чинь тусдаа сантай, тусдаа ерөөлтэй, тусдаа даллагатай, бүгд дээжис **сэржмээ** гэхэд хаана авах вэ, Алтангэрэлээр хаана авах вэ бүгд тус тусын горимтой.

Асуулт:-Аваад морь уралдах, бөх барилдах, наадам хийх үү?

Хариулт:-Ерөөсөө овоонууд бүгд наадамтай. Энэ наадам нь **Дээн солын** овоо гэдэг нь наадамтай.Одоо хүртэл бөх барилддаг.Энэ доод их овоо бол яг овооныхоо хөтөл дээр морио уралдуулдаг, энэ жил хүртэл уралдууллаа шүү дээ.Цогт овоондоо.Бадар хундага гэж бас жижиг хонхортой.Юмныхаа дээжийг хийдэг.Өргөж байгаа юмныхаа дээжийг, идээ цагааныхаа дээжийг хийдэг.Энэ хойд талын **Дээн солын** овоо нь шүүстэй тахидаг.Энэ доод Цогт овоо бол бас шүүстэй тахидаг.Тэгэхдээ шүүсээ тэнгэрт үзүүлдэггүй.Энэ нь дагавар 13 овоотой.Тэгээд 5 өнгийн хадаг, одоо бол 5 өнгийн торго болчихно шүү дээ.Тэгээд **сархадаа** эхэлж өргөөд, тэгээд галдаа тосоо өргөөд, тэгээд бүх л юм л. Энэ чинь тус тусдаа жаягтай, тэр жаяг мэдсэн улсууд л тахина уу гэхээс зүгээр дуртай ном уншдаг лам ирээд тахина гэж байхгүй.

Хамгийн гол нь манай гэгээнтний яаж байгаа юм бол энерги.Ээж ууланд чинь асар их олон цацал дэвсээтэй, 5000-ын.Ерөөсөө хүн явдаггүй газар.Улайтал 5000-тын **цацалнууд** дэвсдэг шүү дээ.100-тынх нь хүн явдаг газруудтай.Яг бид нар нэг агуйд ороод малгай авахад 100-тын цацал байна.Дээр даяанч нь юм хийж байсан лам нарын тавьж байсан. Хамгийн гол нь энэ дээд тахилд Баян-Өндөр, **Жачин жалд**,Гүү бариач, **Дэлэг жүн**, Ээж хайрхан, Цогт овоо, **Дээн сол**, ийшээ Ламын овоо, тэгээд Бурхан буудайн овоо гээд ингээд 13 овоо.

Говьд нь ороод ирэхээрээ говьдоо дандаа булгуудын 13 овоотой.Тусдаа. Дагавар. Булгуудаа хөөгөөд тахиад явчихдаг.Эхлээд хамгийн гол нь итгэлээ уншаад, тэгээд Бурхан буудайнхаа санг тавиад, Ээж хайрханыхаа санг тавиад тэгээд ард талын юмнуудыг хийдэг.Иймэрхүү л юутай, миний мэдэж дуулснаар бол.

Асуулт:-**Төгрөгийн** хүрээний барилга байгууламжийн тухай ярьж өгөхгүй юу, ямархуу хэв маягаар ярьсан юм, ер нь монголчууд барьсан юмуу?

Хариулт:-Барилга байгууламж нь эхлээд товлохдоо Гачин лам гээч хүний дүр товлож байсан юм гэнэ лээ. Энэ доор Дархан хүрээ гэж байдаг юм.Тэр Дархан хүрээн дээр дацан байгуулаад ирсэн чинь тэр Гачин хутагт, хүүхэн хутагт эхлээд **Ачуурт** гэсэн Дархан хүрээндээ байгуулаад, Дархан хүрээ гэдэг нь сумын төвөөс 10-хан км газар.Тэнд дацан байгуулж байсан юм гэнэ лээ.Одоо хойд талын овооноос өөр суурь байдаггүй юм.Тэгээд наашлаад Хүүхэн хутагт ирсэн чинь энэ тохирохгүй нь ээ гэж хэлээд нааш нь ирүүлээд энд Цогчэн дуганыг энэ овгор дээр байгуулсан байдаг юм.Бид нарыг хүүхэд байхад нураагүй байсан.Сүүлд нь нураасан. Тэр нь ямар барилга байгуулсан гэхээр Майдар гуайн юун дээр зураг нь гарчихсан. Урдаа хоёр тусдаа дөрвөлжин асартай, жаал сийлбэртэй, урдаа модтой.Урдаа хоёр өндөр модтой.Нэгнийхээ орой дээр рашаан хийдэг бумба шиг тийм

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бумбатай, хэлбэртэй.Нөгөө тал дээр нь нэл тольтой.Тэгээд хооронд нь хадаг яндар зүүгээд.Жаал ийм унжлагатай. Тэр овгор дээр боссон дуган нь 12 : 12 харьцаатай.

Наад талын гэлэнгүүд хайлан хурдаг дуган нь 9:8-ын харьцаатай байж байгаа. Нэг босоо өрлөгтэй байшин байдаг юм, аж ахуйн байшин байсан юмуу, тэр номын байшин байсан юмуу, тэр нь одоо хүртэл нураагүй, ингээд хувь хүний мэдэлд байж байдаг.Цогчэн дуганыхаа урд талд **Ламрингийн** хийд нь.Тэгээд баруун энгэр дээр нь Ганжуурын хийд, тэгээд **Данжуурын** хийд нь, тэгээд **Сандуйх**, тэгээд Улаан сахиусных, тэгээд **Цогчэнгийнх**. Ингээд 8, 9 хийд байсан.Ийм **тууриуд** нь байж байна л даа.

Асуулт:-Энэ хийдийг тоосгоор барьсан уу? Модоор барьсан уу?

Хариулт:-Энэ дандаа тоосго. Хятад барьж байсан.Зүгээр том том тоосгонүүд.Саяхан хүртэл авсан. 15:30-ын харьцаатай юм байв уу даа, тийм тоосгонүүд.

Асуулт:-Хөх тоосгонүүд уу?

Хариулт:-Үгүй, зүгээр түүхий тоосго.

Асуулт:-Хийдийг барьж байсан хятадуудын талаар та мэдэх үү? Хаанаас ямар?

Хариулт:-Хятадуудын талаар мэдэхгүй. Ямар ч байсан эхний хоёрыг хятад барьсан юм гэнэ лээ.

Асуулт:-Тэр үед хятад **наймаачингууд** энүүгээр байдаг байсан болов уу?

Хариулт:-Байлгүй **яахав**.Пүүсийн хонхор гэж хэлээд **хөтөлийн** цаад талд.Одоо энэ харагдаж байгаа хөтөл дээр нэг жижиг суваргатай, цаад талын хөтөл дээр хэдэн суваргатай ингээд тойрсон суваргуудтай байсан байгаа юм.Тэгээд **суварганыхаа** гадна талд хятадын пүүсүүдийг байрлуулдаг.Тэгээд манай энэ чинь ерөөсөө хятадтай холбоотой шүү дээ.Манай сумын нутаг дэвсгэр чинь хятадын хилтэй холбогддог юм.Урагшаа 300 гаруй км байгаа.Тэгээд жин тээж байсан.Тэмээ эд нарыг нь хэвтүүлж байсан нөгөө**буурь** нь одоо хүртэл бий.

Асуулт:-**Суварганаас** гадагш нь хятадуудыг байлгана гэдэг чинь хийдийн гороонд оруулахгүй байна гэсэн үг үү?

Хариулт:-Оруулахгүй. Гороонд оруулдаггүй, ерөөсөө хятадыг тийш нь оруулдаггүй байсан.

Асуулт:-Төгрөгийн хийд татвар төлдөг байсан болов уу?

Хариулт:-Татвар гувчуур төлдөг.

Асуулт:-Хаана төлөх вэ?

Хариулт:-Хошуундаа л төлдөг байсан байх.

Асуулт:-Ёст бэйсийн хошуу юу? Танай энэ чинь

Хариулт:-Толь гүний хошуу. Итгэмжит гүний хошуу ч гэдэг юм.Засагт хан аймгийн.Түүхийн дун дээр Бурхан буудай уулын хошуу ч гэдэг юм.Их олон хувирч, өөрчлөгдөж байсан.**Ноёдууд** нь өөрчлөгдөөд**нэрнүүд** нь өөрчлөгдөж байсан юмуу, тийм л юм байдаг юм байна лээ.**Жас** бол асар их баян жас байсан.Одоо жасын дэвтрүүд нь над байгаа л даа.Тамгатайгаа. Ямар хүн хандив өргөж байж вэ, ямар татвар төлж байж уу, ямар юм авч байж вэ?Ерөөсөө тамгыг нь дараад дараад.Бүгд түүх.Тэр байтугай Буурал ноён гэж байсан Толь гүний эцгийн үед.Баруун тийшээ явж хятадын пүүстэй наймаа хийж байсан ханз үсгийн бичиг байдаг юм.Тэгээд

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Улаанбаатар руу Чой Лувсанжав гуайгаар орчуулуулахаар очиж байсан.Одоо контракт шүү дээ.Гэрээ. Тийм юмнаас авахуулаад түүхийн баримтууд их байдаг.

Асуулт:-Хэдэн жастай байсан бэ?

Хариулт:-Бүгд 9 дугуй жастай тэндээсээ төв жасдаа яадаг. 12 том ханатай гэртэй.Тэгээд төв жасаа татаад төвлөрүүлчихдэг.Тэгээд энийг төчнөөн лан мөнгө, төчнөөн **унци** алт.Энэ бол ерөөсөө тоймгүй баян байсан.37 оны үед алт мөнгөн хэрэглэл болгоныг нь ийш нь 4 **ЗИС**-5-аар ачсан гэж байгаа шүү дээ.Манай аав ээж давааны Хар энгэр гээч юманд байсан.

Асуулт:-Оросууд аваад явчихсан уу? Ачаад.

Хариулт:-Тийм.Нэгэнт гэрээслэл нь үлдсэн. Хоёрт, манай аавын талын хөгшчүүл бүгд энэ хийдэд байсан лам нар байхгүй юу. Тэгээд би энийг нь дахиж сэргээе, **яахав** дээ, гэхдээ би Ганданд аваачаад 4 лам сургаад **цогчэн** хурдаг тийм болгож байлаа. Сүүлдээ ахуйдаа татагдаад хурал ном ч үгүй болсон. Хааяа маань хуръя гэхээр улсууд очиж маань **хуруулчихаад**.Манай энд чинь 500 гаруй цөгцтэй.Зарим нь дээр үеийнх байна, зарим нь орчин үеийнх байна.**Зарим** нь **Гүмбэнгээс** авчирсан байна.Янз бүрийн.Саяхандаа хүүхдүүд нь аваачаад зарчихлаа.Литр литр ордог ийм цалин цагаан мөнгөн цөгцнүүд байсан.Тэр чинь манай эзэмшилд орж ирэхгүй юм байна шүү дээ.500 сая гээд үнэ хэлчихнэ, **нөгөөдөхийг** нь бид нар хүч хүрэхгүй тэгж байгаад цаашаа зарагдаад.

Манай энд **Ганжуур** 9 эрдэнээр байсан гэж байгаа юм.Тэгээд сүүлд нь Ээж уул руу аваачиж хийгээд тэгээд ээж уулнаас алга болсон юм байна лээ.Тэгээд одоо энд 9 эрдэнийн Жадамба л байна даа.Алтаар бичсэн Алтангэрэл ойр зуурын юм байдаг л юм.

Асуулт:-**Зис**-5-аар хамаг алт мөнгөн эдлэлийг нь ачаад аваад явчихсан юм байна?

Хариулт:-Яг тэрэнтэй холбогдолтой юмыг ийш нь ачиж байсан гэж байгаа.

Асуулт:-Тэгээд сүм хийдийг нурааж байхгүй болгосон уу?

Хариулт:-Сүм хийд нь эндээс албаар хүн нураагаагүй гэж байгаа юм. Энд модыг нь авч ашиглаад, сүүлд нь аялал гээч юм болоод.Намайг хүүхэд байхад энэ чинь бүтэн байж байлаа шүү дээ, 2 дуган.**хайлан**, Цогчэн хоёр дуган.

Асуулт:-Хэдэн оны хавьд байх уу?

Хариулт:-63 оны үед бүтэн байсан байхгүй юу. Оройтой. Манай ангийн дарга хүн түүврын мал тоолдог, мах хураадаг юм хийнэ гэж хэлээд тэгээд аль ч үгүй болсон.Цогчэн **дуганын** дээврийг нь авч хаяад тэгээд энэний түүхэн цогчэн дуган байсны усны тосгуур, хаалганы мод бол хийд дээр байна л даа.